

[Корона-19] Дотоодод(Солонгост) вакцин хийлгэсэн хүн хилээр орж ирэх үед тусгаарлалтаас чөлөөлөгдөх тухай мэдэгдэл]


Гадаад оюутнууд дунд Солонгос улсад вакцин бүрэн хийлгэн гадаад руу гарсны дараа Солонгос улсруу дахин орж ирэх тохиолдолд, вакцин хийлгэснээс хойш 14 хоног өнгөрсөн бол тусгаарлалтаас чөлөөлөгдөх боломжтой юм. Доорх урсгал диаграммыг шалган, аюулгүйгээр гадаадад суралцах болон хилээр орж ирэхэд хялбар байлгахын төлөө дотоодод оршин сууж буй гадаад оюутнууд нь вакцинаа бүрэн хийлгэхийг хүсье.

○ Дотоодод вакцин хийлгэсэн хүн тусгаарлалтаас чөлөөлөгдөх нөхцөл

- ① Солонгос улсад вакцин бүрэн хийлгэсэн байх (вакцин хийлгэснээс хойш 2 долоо хоног өнгөрсөн байх)
 - * Жишээ нь: Солонгос улсад вакцин хийлгэж дуусгасан өдөр 9.1 байх тохиолдолд, буцан ирэх өдөр 9.16 өдрийн 0 цагаас хойш бол тусгаарлалтаас чөлөөлөгдөх боломжтой
- ② Корона-19 сэжигтэй шинж тэмдэггүй байх
- ③ Доорх улсаас ирж байгаа тохиолдол биш байх (* хамаарах улс нь сар бүр солигддог)

***(11 сар) Манай сургуулиас хамаарах улс: Үзбек, Казахстан, Киргиз, Филиппин**
↳ Дээрх улсад хамаарах тохиолдолд, Солонгос улсад вакцин хийлгэсэн байсан ч Солонгос улсын хилээр орж ирэх үед тусгаарлалт заавал хийх шаардлагатай

○ Хэрэгжих шат дамжлага



○ Вакцинжуулалтын гэрчилгээ авах арга: Гадаадруу гарахын өмнө хамаарах эрүүл мэндийн төвөөс лавлан авах

○ Бусад анхаарах зүйл

- Дотоодод(Солонгост) вакцин хийлгэгч нь тусгаарлалтаас чөлөөлөх нөхцлийг хангахгүй тохиолдолд тусгаарлалтаас чөлөөлөгдөх боломжгүй
- Дотоодод вакцин хийлгэгч нь онгоцны буудлаас явахдаа нийтийн тээвэр ашиглах боломжтой(боломжтой бол машин ашиглах), хөдлөх явцад өөр газраар оролгүй шууд тусгаарлалтын байр руу явах шаардлагатай
- Солонгос биш гадаадад вакцин хийлгэсэн тохиолдолд, тусгаарлалтаас чөлөөлөгдөх боломжгүй (Хилээр орж ирэх үедээ 10 хоног тусгаарлалт хийх шаардлагатай)